

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2017 оны 12-р сарын 27-ны байдлаар


2017 оны 12-р сарын 27-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 1.6 хувиар буурч, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.2 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2017 оны 12-р сарын 27-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 5.4 хувь, үхрийн ястай махны үнэ 3.5 хувь, үхрийн цул махны үнэ 2.8 хувь, ямааны ястай махны үнэ 9.1 хувиар буурсан бол адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад ямааны ястай махын үнэ 0.9 хувиар буурч, бусад махны үнэ өөрчлөлтгүй байна.

2017 оны 12-р сарын 27-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 5090 төгрөг, үхрийн /ястай/ мах 6475 төгрөг, үхрийн цул мах 7935 төгрөг, адууны /ястай/ мах 4900 төгрөг, ямааны /ястай/ мах 3435 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2017 оны 12-р сарын 27-ны байдлаар гурилын үнийг өмнөх сарынхтай болон өмнөх 7 хоногтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2017 оны 12-р сарын 27-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2017 оны 12-р сарын 27-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 8.5 хувь, хүрэн манжингийн үнэ 6.3 хувь, луувангийн үнэ 3.1 хувь, байцааны үнэ 2.1 хувиар тус бүр буурсан бол сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад төмсний үнэ 4.0 хувь, хүрэн манжингийн үнэ 5.2 хувь, луувангийн үнэ 2.0 хувь, байцааны үнэ 1.6 хувиар буурч, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2017 оны 12-р сарын 27-ны байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад, “Элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 1.1 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 2.6 хувь, задгай сүүний үнэ 14.3 хувиар өссөн байна. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад задгай сүүний үнэ 10.3 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.4 хувиар өссөн бол “Элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас 0.5 хувь, цөцгийн тосны үнэ 1.8 хувиар өссөн бол өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.